



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



**“ХАНГАЙН НУРУУНЫ БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОР ГАЗАРТ ОЙН ТОГТВОРТОЙ
МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ”-НИЙ
АЖЛЫН ТАЙЛАН**

**Д.МӨНХЗОРИГ
МОНГОЛЫН ОЙН ТОГТВОРТОЙ МЕНЕЖМЕНТИЙН ЗӨВЛӨЛ ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**

2020 оны 9 сарын 04



Мэдээллийн агуулга

1. Төсөл хэрэгжүүлэгч
2. Төслийн танилцуулга, ажлын даалгавар, зорилго, хэрэгжүүлэх газар, хугацаа
3. Төслийн үр дүн, шалгуур үзүүлэлт
4. Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, гүйцэтгэсэн ажил
5. Төслийн үр дүн, зөвлөмж





1. Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ын танилцуулга

Ойн салбарын эрдэмтэд, мэргэжилтнүүд, төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, байгууллагууд, ойн нөхөрлөлийн төлөөлөл оролцсон 19 хүний санаачлагаар Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ нь 2015 оны 4 дүгээр сарын 13-нд байгуулагдсан бөгөөд удирдах зөвлөл нь ойн салбарын тэргүүлэх эрдэмтэд, мэргэжилтнүүд 11 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага юм. Манай төрийн бус байгууллага нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Ойн тухай хуулийн 25 дугаар зүйлийг мөрдлөг болгон ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, ойн менежментийг хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг явуулж байна.

Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ нь байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол улсын ойн салбарт тогтвортой менежментийг нэвтрүүлэх, ойн мэргэжлийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэх, Ойн талаар төрөөс баримтлах бодлогод тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд БОАЖЯ, олон улсын төсөл, хөтөлбөрүүд, орон нутгийн байгууллагууд, Ойн анги, ойн мэргэжлийн байгууллага, ойн нөхөрлөлүүдтэй идэвхитэй хамтран ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд манай ТББ нь ГТХАН-ийн “Биологийн олон янз байдал ба уур амьсгалын өөрчлөлтөд ойн гол экосистемүүдийн дасан зохицох нь II” хөтөлбөрийн “Монгол улсад Ойн тогтвортой менежментийн магадлан итгэмжлэлийг нэвтрүүлэх”, Монгол орны UN-REDD Үндэсний хөтөлбөрийн “Ойн хомсдол, доройтлыг бууруулах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх бодлого, арга хэмжээг тодорхойлох”, “Төв, Булган аймгуудын ойн хомсдол доройтлыг бууруулах ойн тогтвортой менежментийн дэд хөтөлбөр боловсруулах”, БОАЖЯ-ны Ойн бодлого, зохицуулалтын газрын “Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх технологийн заавар боловсруулах”, “Орон нутагт ойжуулалт, ойг нөхөн сэргээх ажлын бүсчилсэн хэлэлцүүлэг зохион байгуулах”, “Ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох журам боловсруулах” зэрэг сэдвээр зөвлөх үйлчилгээ үзүүлж ирлээ.



2. Төслийн танилцуулга, ажлын даалгавар, зорилго, хэрэгжүүлэх газар, хугацаа

Монгол Улсын Засгийн Газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн Газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Германы Сэргээн Босголтын Зээлийн Банкаар дамжуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийг 2015 оноос 2020 оныг хүртэл 5 жилийн хугацаанд хэрэгжүүлж байна.

Загвар төслийн зорилго: Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицсон ойн тогтвортой менежментийг Хангайн Нурууны БЦГ-т нэвтрүүлэх замаар тус газрын ойн экосистемийг нөхөн сэргээх, хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, ойн хомсдол, доройтлыг бууруулах, нутгийн иргэдийг амьжиргааг дээшлүүлэх ажлын менежментийг сайжруулах, тогтвортой болгоход оршино.

Загвар төсөл хэрэгжүүлэх нутаг нь Архангай аймгийн Цэнхэр сумын Хангайн нурууны БЦГ-ын Орчны бүс (ОБ)-д хамрагдах нутаг дэвсгэр болно. Энэ нутгийн ойн сангийн талбайн нийт хэмжээ 23365 га бөгөөд түүний 22773 га шинэс ой, 988 га хушин ой эзэлж байгаа ба тэр дундаа нас гүйцсэн хөгширсөн ой зонхилж байна. Архангай аймгийн Цэнхэр суманд ойн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий мэргэжлийн байгууллага 8, ойн нөхөрлөл 16 байдаг бөгөөд ойн асуудал эрхэлсэн орон нутгийн ойн анги Архангай аймгийн засаг даргын тамгын газарт харьяалагддаг. Ойн эрх бүхий мэргэжлийн байгууллагууд нь ойгоос цэвэрлэгээний огтлолтоор жилд 20-30 га талбайд мод бэлтгэж, хөрөө рам ажиллуулдаг боловч мод үржүүлэх, ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийх ажлын туршлага сул байна. Ойн нөхөрлөлүүд ойн цэвэрлэгээний ажилд туслан гүйцэтгэгчээр оролцдог. Хангайн нурууны БЦГ-т өмнө нь арчилгааны огтлолт, ойжуулалт болон ойг нөхөн сэргээх арга хэмжээ хэрэгжүүлж байсан ажлын туршлага байхгүй.

Загвар төслийг 2019 оны 7-р сараас 2020 оны 9 сар хүртэл 12+2 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.



3. ТӨСЛИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Үр дүн 1: Хангайн нурууны БЦГ-ын ОБ-д ойн тогтвортой менежментийн оролцогч талуудын чадавх бэхжиж, ажлын уялдаа холбоо сайжирсан байна.

Шалгуур: ХНБЦГ-ын ойн менежментэд оролцогч талуудын 80%-аас доошгүйг чадавх бэхжүүлэх сургалтанд хамруулсан байна.

Үр дүн 2: Хангайн нурууны БЦГ-ийн ОБ-д сонгогдсон ойн тогтвортой менежмент хэрэгжүүлэх нэгжийн загвар ойн менежмент төлөвлөгөө, түүнд түшиглэсэн бизнес загвар боловсрогдож, тус нэгжийн ойн сангийн хамгаалалт, нөхөн сэргээлт, зохистой ашиглах менежмент сайжрах, орлого тогтворжих нөхцөл бүрдсэн байна.

Шалгуур: Сонгогдсон ойн санг гэрээгээр эзэмших эрх бүхий нэгжийн ойн менежмент төлөвлөгөөнд суурилсан 2 бизнес загвар хөгжүүлсэн байна.

Үр дүн 3: Хангайн нурууны БЦГ-т ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын чанарыг сайжруулах, менежментийн түвшинд тогтвортой байдлыг хангасан дэд бүтэц, хүчин чадал хамгаалалтын захиргаанд бий болсон байна.

Шалгуур: Жилдээ 1-2 настай 20 мянган ширхэгээс доошгүй тарьц, суулгац үйлдвэрлэх хүчин чадалтай мод үржүүлгийн газар байгуулагдсан байна.





4. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

2019 оны 7 сарын 18-ны өдөр “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөлтэй Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ “Хангайн нурууны байгалийн цогцолборт газарт ойн тогтвортой менежментийн загвар төслийг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ” үзүүлэхээр ҮТ-04/2019 дугаар гэрээг байгуулсан билээ. Монголын ойн тогтвортой менежментийн зөвлөл ТББ-ын зөвлөх баг нь загвар төслийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийг төслийн удирдлагатай зөвшилцөн баталсан. билээ. Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дээр дурьдсан ажлын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийн дагуу гүйцэтгэж байгаа болно. Төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахи ажлыг гүйцэтгээд байна. Үүнд:

1.Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай баримт бичгийг холбогдох газруудаас авч судалсан. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж, заавар журмууд
- 2016 онд ШУА-ийн Газар зүй, Геоэкологийн хүрээлэн гүйцэтгэсэн Хангайн Нурууны БЦГ, түүний ОБ-ийн ойн тогтвортой менежментийн суурь мэдээлэл бүрдүүлэх судалгааны ажлын тайлан, ойн зураг.
- Энэхүү суурь судалгааны ажлын үр дүнд тулгуурлан 2018 онд тус төслөөс боловсруулсан Архангай аймгийн Цэнхэр сумын Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын ОБ-д ойн тогтвортой менежментийн загвар үзэл баримтлал.
- Цэнхэр сумын ТХГН, тэдгээрийн ОБ, орон нутгийн хамгаалалттай газар, эко-коридоруудын батлагдсан менежментийн төлөвлөгөө.
- 2018 оны Цэнхэр сумын Ой зохион байгуулалтын материал, зураг.
- Цэнхэр сумын ТХГН, тэдгээрийн ОБ-д орших ойн нөхөрлөл, аж ахуйн нэгжийн байршил, судалгаа.



4. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

3. Хангайн нурууны байгалийн цогцолборт газарт ойн тогтвортой менежментийн загвар төслийг хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ”-ний ажлын даалгаврыг хангах зорилгоор зөвлөх үйлчилгээний багийн ахлагч академич доктор Ч.Доржсүрэн, багийн гишүүн ой судлаач Л.Доржцэдэн, Д.Мөнхзориг нар 2019 оны 7 дугаар сарын 30-наас 8 дугаар сарын 2-ны өдрүүдэд Архангай аймгийн Эрдэнэбулган, Цэнхэр сумдад ажиллалаа. Хангайн нурууны байгалийн цогцолборт газарт төслийн хүрээнд судалгаа явуулах ойн нөхөрлөлийн ойн талбай, аж ахуйн нэгжийг сонгож, мод үржүүлгийн газрын байршлын талаарх саналыг холбогдох газруудаас авсан болно.





4. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

4.Төслийн багийн гишүүд Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын ажилтан Болдбаатар, аймгийн Ойн ангийн инженер Даваахүү нарын хамт Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын Ширдэгийн голд байрлах байгаль хамгаалагчийн байр, орчны ойн сангийн ерөнхий байдалтай танилцаж, энэ орчинд амьдардаг Ч.Алтансүх, Ц.Норов, Б.Лувланжалав нарын өрхүүдээр орж ойгоос болон аялал жуулчлалаас олж болох орлогын талаар мэдээлэл авав.

5.Цэнхэр суманд үйл ажиллагаа явуулж байгаа Тэлээ таван хайрхан ХХК-ны захирал Ч.Дангаатай уулзаж төсөлтэй хамтарч ажиллах боломжийн талаар ярилцаж тохиров.

6.Аймгийн Ойн ангийн Цэнхэр суманд байрлах Мод үржүүлгийн газар, хүлэмжийн үйл ажиллагаа, тарьц суулгацын ургалт, хөрс, усны хангамжийн байдалтай танилцаж, энэ мод үржүүлгийн газрыг өргөтгөх боломжийн талаар ярилцав. Мод үржүүлгийн газар нь 2.0 га талбайтай, 60 мкв талбай бүхий 2 хүлэмжтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ойн мэргэжлийн 2 ажилчинтай, худгаас цахилгаан моторын тусламжтайгаар усалгаа явуулж байна. Холбогдох байгууллагуудын удирдлагатай уулзаж, МҮГ-ын байршлын талаар саналыг албан ёсоор авсан болно.






4. ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

9. Ч.Доржсүрэн ахлагчтай судалгааны баг Цэнхэр сумын Үйзэн Хайрхан нөхөрлөлийн эзэмшлийн ойн сангийн 72, 73, 74, 87, 88-р хэсэглэлийн (compartment) нийт 4691 га ойн талбайд 2019 оны 8-р сарын 21-нээс 16 хоног хээрийн маршрут судалгаа хийж, 705 га талбайтай 72-р хэсэглэл, 823 га талбайтай 88-р хэсэглэл, нийт 1528 га талбайг сонгож ялгарлын түвшинд ойн тооллого, ой зохион байгуулалт хийв.

10. Ч.Доржсүрэн ахлагчтай судалгааны баг, Үйзэн Хайрхан нөхөрлөлийн ойн мэргэжилтэн О. Аръяабалтай хамтран 2019 оны 10-р сарын 2-ноос 4 хоног Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг Цэнхэрийн гол, Ширдэгийн гол, Нарийн хамрын голын дагуу шинэсэн ойд маршрут судалгаа хийсний үндсэн дээр Нарийн хамрын голын Цагаанчулуут хэмхээх газар 3,7 га шинэсэн ойн үрийн талбайг сонгож, 4 талд нь шон зоож тусгаарлаж, Үйзэн Хайрхан нөхөрлөлд хүлээлгэж өгөв.





Ойн менежментийн төлөвлөгөө

Нөхөрлөлийн эзэмшил ойн менежмент төлөвлөгөө боловсруулах ажлыг бэлтгэл үе, ой тооллого, зохион байгуулалтын хээрийн судалгаа, материал боловсруулалт, төлөвлөгөө боловсруулж батлуулах гэсэн 4 үе шаттай гүйцэтгэв.

1-р үе шат - бэлтгэл үе 2019 оны 8 сар

Нөхөрлөлийн ойн сангийн суурь мэдээллийг цуглуулав (Хангайн нурууны байгалийн цогцолбор газрын болон ойн нөхөрлөлийн ой зохион байгуулалтын мэдээ, тайлан, хэрэгжүүлж байсан ойн менежментийн төлөвлөгөө)

2-р үе шат - хээрийн хэмжилт, судалгааны ажлын үе. 2019 оны 9-10 сар

-Нөхөрлөлийн эзэмшлийн ойн санд хамаарах 72, 74-р хэсэлэлийн 1528 га талбайн 29 ялгарал бүрт 2 цэг сонгож, цэг бүрт 3 тойрог дээж талбай байгуулж ойн тооллого хийх аргаар ой зохион байгуулалт хийв.

Нөхөрлөлийн гишүүдийн саналыг авч, ойн менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилтыг тодорхойлж, тулгамдаж буй асуудал бэрхшээл, нөхөрлөлийн ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх чадавхыг тодорхойлов.

-Нөхөрлөлийн гишүүдээс ойн сангийн зэрлэг амьтан, ургамлын талаар мэдээлэл, судалгаа авсан.

3-р үе шат - материал боловсруулалтын үе. 2019 оны 10-11 сар

-Эзэмшлийн ойн сангийн нарийвчилсан судалгаа явуулсан 1528 га ойн сангийн тооллоын материалыг боловсруулж ойн төлөв төлөв байдал, таксацын үзүүлэлтийг тогтоов.

-Ойн аж ахуйн арга хэмжээ, биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагааг төлөвлөв.

-Ойн сангийн тооллого хийсэн хэсэглэлийн тойм болон тархалтын зураг боловсруулав.


4-р үе шат - эзэмшлийн ойн сангийн экологи эдийн засгийн үнэлгээг тооцож, ойн менежментийн төлөвлөгөөг эцэслэн боловсруулж, хэлэлцүүлэг хийж батлуулах, нөхөрлөлд хүлээлгэж өгөх үе. 2019 оны 12, 2020 оны дүгээр сар

“Үйзэн хайрхан ойн нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөө”-ний төсөл боловсруулж, захиалагч байгууллага болох “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төслийн баг, Хангайн нурууны байгалийн цогцолбор газрын захиргаа, сум дундын ойн анги, Цэнхэр сумын захиргаанд танилцуулав. Гарсан санал зөвлөмжийн дагуу “Үйзэн хайрхан ойн нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөг эцэслэн боловсруулж, баталгаажуулахад бэлдсэн.




Ойн менежментийн төлөвлөгөө

14-р хүснэгт. Цэвэрлэгээний ажлын төлөвлөгөө



№	Хэсэглэл, ялгарал газрын нэр	Талбай (га)	Цэвэрлэгээний ажлаас гарах нөөц (шоо.метр)	Хэрэгжүүлэх хугацаа			Нийт нөөц (Шоо.метр)
				2019-2021	2022-2025	2026-2028	
Цэвэрлэгээний ажил							
1	72, 74-р хэсэглэл	10	Түлээ	100 ш.м	-	-	100 ш.м
2		20	Түлээ	100	100 ш.м	-	200 ш.м
3		30 га	Нийт	100 ш.м	200 ш.м		300 ш.м
Цэвэрлэгээний огтлолт							
4		50	-	150	150	200 ш.м	500 ш.м
Нийт дүн		га	Түлээ	450	450	500 ш.м	500 ш.м





Мод үржүүлгийн газар, хүлэмж

Цэнхэр сум дахь СДОА-ийн харьяа МҮГ-т 6х20 м хэмжээтэй БНСУ-д үйлдвэрлэсэн нийлэг хаьсан хүлэмжийг “Мөнх ногоон тал” ХХК-аас авч Хүлэмжийг мэргэжлийн байгууллагаар шаардлагын түвшинд угсруулж ажилд бэлтгэв.

Хөрс боловсруулалт, тарилт, арчилгаа усалгааны ажлыг технологийн нарийн горимын дагуу гүйцэтгэж, дээр дурдсан оролцогч ажилчдад гарын авлага материал бэлтгэн тарааж, хичээл зааж арга технологийн зохих мэдлэгийг олгосны үндсэн дээр урьдчилан боловсруулсан “Нийлэг хүлэмжинд шинэсний тарьц үржүүлэх ажлыг гүйцэтгэх график”, “Нийлэг хальсан хүлэмжинд шинэсний тарьц ургуулах технологи” зэрэг удирдамж зааврыг мөрдөж ажиллав.





Архангай аймгийн цэнхэр сум нийлэг хальсан хүлэмжинд шинэс тарих (Үйл ажиллагааны зурагт тайлан)



1. Ширэгт хөрсийг хуулж занлуулаад ул хөрсийг сайруулэх



2. Ул хөрсийг боловсруулж дууссаны дараа



3. Хар шороо 16 тн, элс 5 тн, бууц 3 тн татав



5. Шигшсэн хөрсийг харьцаагаар нь ачих



6. Хөрсийг тэргэнцэрт хөлийх



4. Хар шороо бууц буталж шигших



7. Хөрсийг хашлагад хөлийх



8. Хөрс бэлтгэсний дараа



9. Хөрсийг бэлтгэж дууссаны дараах усалгаа, ариутгал



10. Үр дэвтгээх ариутгал



11. Үр тарих ховилд тусгай хөрс бэлтгэж хийв.



12. Үр тарих ажиллагаа



13. Үр тарьсны дараах усалгаа



14. Хүлэмжийн бичил уур амьсгал



15. Үр тсөёлолт



16. Нагах өвчнөөс хамгаалах ариутгал



17. Арга технологийн сургалт хийж, гарын авлага тараав









18. Хүлээлгэж өгөх үлдээ



Мод үржүүлгийн газар, хүлэмж


Хүлэмжинд хийгдэх арчилгаа, усалгааны ажилд шаардагдах 8.173.350 төгрөгний үнэ бүхий 16 төрлийн БНСУ-д үйлдвэрлэсэн өндөр чанартай багаж хэрэгсэл тоног төхөөрөмжийг “Мөнх ногоон тал” ХХК, “Соёолж” ХХК-уудад захиалан авч тарилтын ажилд хэрэглэн СДОА-д хүлээлгэн өгөв.

д/д	Багаж хэрэгсэл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Бүгд үнэ	Зураг
1	Хүлэмж сүүдэрлэх бүтээлгийн хамт	1	3850000	3850000	
2	Хүрз	6	28000	168000	
3	Тармуур Гапу	4 1	25000 22000	100000 22000	
4	Услуур	4	22500	900000	
5	Түрдэг тэрэг	1	105900	105900	
6	Хор шүршигч	1	168000	168000	



Мод үржүүлгийн газар, хүлэмж

- СДОА-ийн худгийн ундарга нь 1 л/сек байсан бөгөөд бид тус худгийг тодорхой зардал гарган лайдуулснаар ундарга нь 3 л/сек орчим болж одоогийн нөхцөл дэх усалгааны хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүрсэн болно.
- Хүлэмжийг 1м өргөнтэй 4 тууз болгож /20-100-50-100-60-100-50-100-20/ харьцаагаар тарилтын даланг байгуулж банзан хашлага хийв. Хашлагад хар шороо 65,2%, элс 21,7%, бүүц 13% харьцаа бүхий хөрсийг бэлтгэв.
- Хүлэмжинд термометр болон агаарын чийгшлийг тодорхойлогч психрометрийг байрлуулж агаарын температурыг 30- 35° хөрсний гадаргын температур 40°-аас илүүгүй, агаарын харьцангуй чийгшил 70-80% байлгах горимыг мөрдөж ажиллах зааварчлагыг өгч ажиллуулав.
- Одоогийн байдлаар хүлэмжний 480 пог/м талбайд 96000 мян ширхэг цухуйц гарсан





Бизнес төлөвлөгөө

Нөхөрлөлийн үйл ажиллагааны чиглэлүүд:

Нөхөрлөлийн гишүүдийн үндсэн үйл ажиллагаа нь мал аж ахуй боловч ойн менежментийн хүрээнд Ойг хамгаалах, ойг арчлах, ойжуулалт, мод үржүүлэх үйл ажиллагаа эрхлэх, байгалийн дагалт баялаг ашиглах зэрэг хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг явуулах бөгөөд энэ хүрээнд арчилгаа, цэвэрлэгээний огтлолт хийх мэргэжлийн байгууллага болох “Тэлээ таван хайрхан” ХХК-тай хамтран ажиллах юм.

“Үйзэн хайрхан” нөхөрлөлийн хүрээнд хэрэгжих бизнес төлөвлөгөөг ойн нөхөрлөлийн дунд шатны бизнес төлөвлөгөөний түвшинд гүйцэтгэлээ. энэхүү төлөвлөгөө нь удиртгал болон 7 хэсгийн бүрэлдэхүүнтэй. Тухайлбал,

- Удиртгал хэсэгт бизнес төлөвлөгөөний ач холбогдол түүнд тавигдах шаардлагууд, тус бизнес төлөвлөгөөний товч агуулгыг танилцууллаа.
- Нэгдүгээр хэсэгт нөхөрлөлийн танилцуулга үйл ажиллагааны чиглэлүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх бизнес бүлгүүдийг тодорхойлов.
- Хоёрдугаар хэсэгт нөхөрлөлийн одоогийн байдалд хийсэн SWOT дүн шинжилгээг үзүүлэв.
- Гуравдугаар хэсэгт нөхөрлөлийн үйл ажиллагааны чиглэлүүд, маркетингийн төлөвлөгөө, идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүдийг оруулав.



Бизнес төлөвлөгөө

- Дөрөвдүгээр хэсэг нь хамгийн гол хэсэг бөгөөд энд санхүүгийн төлөвлөлт тусгагдлаа. Санхүүгийн төлөвлөгөөг орлогын эх үүсвэр, зардлын төсөвлөлт, үр ашгийн тооцоо, хөрөнгө оруулалтын эргэн төлөгдөх хугацаа зэрэг үзүүлэлтүүдээр бизнес бүлэг тус бүрээр тооцов. Мөн энэ хэсэгт шинээр эрхлэх Зөгийн аж ахуйн төслийн бизнес төлөвлөгөөг тооцоолж оруулав авч үзэв.
- Тавдугаар хэсэгт өрсөлдөгчдийн судалгааг бизнес бүлэг тус бүрээр гаргав.
- Зургадугаар хэсэг бол эрсдлийн төлөвлөгөө. Нөхөрлөл нь байгаль, цаг уурын бэрхшээл, мөн зах зээлийн нөхцөл, үйлчлүүлэгчдийн тоо, сонирхол буурах, санхүүгийн хүчин зүйлс зэрэг гэнэтийн ямар нэгэн хүндрэл, дэд бүтцийн болон эрхзүйн орчинд гарсан өөрчлөлт зэргээс шалтгаалан бизнесийн зорилгыг хэрэгжүүлэх үйл явц удаашрах болон зарим үйл ажиллагаанууд биелэгдэхгүйд хүрч болно. Тохиолдох эрсдэлүүдийг урьдчилан тооцохдоо илрэх хэлбэр, учирч болох үр дүн, тухайн эрсдэлээс хамгаалах, зайлсхийх, тараан байршуулах арга хэмжээнүүдийг төлөвлөв.
- Долдугаар хэсэгт хяналт үнэлгээ хийх зарчим арга замыг заав.



Бизнес төлөвлөгөө

Нөхөрлөлийн үйл ажиллагааг дөрвөн үндсэн чиглэл болгож бизнес бүлгүүдэд хариуцуулан хэрэгжүүлнэ. Бизнес бүлгүүдийг доорх байдлаар зохион байгуулан ажиллуулна.

Маркетингийн төлөвлөгөөг бизнес бүлэг тус бүрээр хийсэн бөгөөд эрсдлийн төлөвлөгөөг бизнес бүлгүүд ашиг алдаглаа харилцан нөхөх байдлаар төлөвлөв.

Бизнес бүлгүүд		Шаардагдах мэдлэг чадварын түвшин	Ажил үүргийн чиглэл	Бүлгийн ахлагч Гишүүд
1	Ойн аж ахуйн арга хэмжээ	Ойн аж ахуйн арга хэмжээний анхан шатны мэдлэг эзэмшиж, үйл ажиллагаа явуулах чадвартай болсон байх	Ойн мэргэжлийн байгууллага болох “Тэлээ таван хайрхан” ХХК-ий үйл ажиллагаан туслан гүйцэтгэгчээр оролцоно	Дангаа А.Орхонтуул Нөхөрлөлийн гишүүд
2	Байгалийн дагалт баялаг ашиглах	Самар жимс мөөг эмийн ургамлыг ашиглах эрхзүйн үндэс, бэлтгэх уламжлалт болон шинжлэх ухааны арга технологийн мэдлэг эзэмшсэн байх	Менежментийн төлөвлөгөө болон ой зохион байгуулалтын материалд тусгагдсан талбайд арчилгаа, хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагааг явуулна	Т.Жамбалсүрэн Ж.Юнэрэн Нөхөрлөлийн гишүүд
3	Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлж борлуулах	Бэлтгэх үр, үржүүлэх мод сөөгний биологи экологийн онцлог үржүүлэх агротехникийн мэдлэг эзэмшсэн байх	- Үр бэлтгэх талбайд арчилгаа хамгаалалтын ажлыг явуулж стандартын шаардлага хангасан үр бэлтгэх - Хүлэмж мод үржүүлгийн талбайд шинэс хайлаасны тарьц үржүүлэх	Ч.Дангаа О.Аръяабал Х.Цэрэнтогтох Компанийн ажилчид
4	Нийтлэг үйл ажиллагаа	Мал аж ахуй эрхлэх уламжлалт мэдлэг	-Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх - Аялагч жуулчдад унаа морь хөлслүүлэх	Нөхөрлөлийн бүх гишүүд



5. Төслийн үр дүн, дүгнэлт

1.Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрийн талаар:

Ойн загвар төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрүүдэд оролцогч талуудын санал, зөвлөмж бүрэн туссан.

2.Ойн нөхөрлөл, ойн мэргэжлийн байгууллагыг сонгох, тэдгээрийн ойн санд судалгаа явуулах талбай сонгох, ойн тооллого, ойн менежментийн төлөвлөгөө хийх талаар:

Цэнхэр суманд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг Тэлээ таван хайрхан ХХК, байгалийн цогцолборт газрын орчны бүсэд 4.69 мянган га ойн сан эзэмшдэг Үйзэн хайрхан ойн нөхөрлөлийг сонгож, тэдгээрийг хоршиж ажиллуулах боломжтой гэж үзсэн. Үйзэн хайрхан ойн нөхөрлөлийн ойн сангийн 1528 га талбайг сонгож ялгарлын түвшинд ойн тооллого, ой зохион байгуулалт хийв.

3.Мод үржүүлэгийн газар байгуулах талаар:

Цэнхэр суманд СДОА-ийн эзэмшлийн МҮГ-т 6х20 хэмжээтэй хүлэмж байгуулж эхний жилийн байдлаар 90.000 ширхэг тарьц ургуулав. МҮГ-ийн худгийг лайдаж ундаргыг нэмэгдүүлсэн. МҮГ-ийн үйл ажиллагаанд ашиглах багаж тоног төхөөрөмжөөр хангасан. МҮГ-ийн модон хашааг сэргээн засварлав.

4.Ойн үрийн талбай тусгаарлах талаар:

Цэнхэр сумын Нарийн хамрын голын Цагаанчулуут хэмээх газар Үйзэн Хайрхан нөхөрлөлийн шинсэн ойд 3,71 га үрийн талбай тусгаарлаж актаар хүлээлгэв өгсөн.

5. Сургалтын талаар

Нийт 7 сэдэвт сургалтад 40 гаруй хүн хамрагдсанаас 1 сургалт нь хүлэмжинд шинэсний тарьц ургуулах, хөрс бэлтгэх, тарьцын арчилгааг практик дээр хэрэгжүүлэв.

7.Бизнес төлөвлөгөө

4 бүлэг бүхий бизнес төлөвлөгөө боловсруулав.

8.Зөвлөмжүүд

Байгалийн цогцолбор газрын ойн менежментийн оролцогч талуудын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх зөвлөмж

Загвар төслийн үр дүнг түгээн дэлгэрүүлэх болон төслийн тогтвортой байдлыг хангах талаархи зөвлөмж

Анхаарал тавьсанд баярлалаа



Promote the sustainable forest management

Web site: www.forest.mn
Email: munkhzorig@forest.mn
Tel: 70009501, 88119501

SPS #405

Ногоон нуурын гудамж 13/2
Сүхбаатар дүүрэг IX хороо
Монгол улс Улаанбаатар хот